



ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 468

Улаанбаатар хот

Эрсдэлийн удирдлагын дотоод  
журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Чанарын менежментийн тогтолцоо MNS/ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлж байгаатай холбогдуулан “Эрсдэлийн удирдлагын дотоод журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Баталсан журмын дагуу эрсдэлийн удирдлагын арга хэмжээ авч ажиллахыг Нэгжийн дарга нарт болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Д.Дашцэцэг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



н.ТӨГСДЭЛГЭР

Газрын даргын 2024 оны ... дугаар  
сарын 15...-ны өдрийн ... дугаар  
тушаалын хавсралт



## ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэл үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хот байгуулалт, хотын стандартын газрын хэвийн үйл ажиллагаа, бодлого, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдэлийн үр дагаврыг хамгийн бага түвшинд байлгах, түүнээс үр ашигтай гарах замаар эрсдэлийг удирдахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Эрсдэл, түүнийг удирдах, үнэлэх үйл явц

2.1. Эрсдэл гэж байгууллага зорилго, зорилтдоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно.

2.2. Эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, тооцох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг бууруулах зэрэг эрсдэлийн удирдлагын арга хэмжээг газар, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

2.3. Эрсдэлийн мониторинг, хяналт шинжилгээг тасралтгүй хийж, үр дүн, явцыг байгууллагын удирдлагад тогтмол мэдээлнэ.

2.4. Эрсдэлийн үнэлгээний үр дүнгээр гүйцэтгэлийн төлөвлөгөө болон цаг үеийн ажлыг тодотгож байна.

2.5. Эрсдэлийн үнэлгээ, мониторинг хийхэд бүх нэгж, албан хаагчид оролцно.

2.6. Үнэлгээний баг бүрдүүлэн хийж болно. Мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан тохиолдолд зөвлөхүүдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно.

2.7. Үнэлгээг хийхдээ "Эрсдэлийн менежмент-Эрсдэлийн үнэлгээний арга MNS ISO 31010:2020" стандартыг баримтална.

Гурав. Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлт

3.1. Байгууллагын удирдлага нь дараах байдлаар эрсдэлийг удирдана.

3.1.1. Эрсдэлийн удирдлагын дотоод журмыг батлах, өөрчлөх;

3.1.2. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах;

3.1.3. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшинг тодорхойлох;

3.1.4. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.5. Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг сонгож удирдлага батлах.

3.2. Захиргааны нэгж нь дараах байдлаар эрсдэлийг удирдана.

3.2.1. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ заавал эрсдэлийн үнэлгээ хийнэ;

3.2.2. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах;

3.2.3. Эрсдэлийн талаар удирдлага, албан хаагчдыг байнгын мэдээллээр хангана;

3.2.4. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, хэрэгжилтийг тогтмол хянана.

## Дөрөв. Хариуцлага

4.1. Эрсдэлийг зохих аргачлал, зарчмаар үнэлээгүй, мэдээлээгүй, эрсдэлийг төлөвлөгөөндөө оруулж тусгаагүй, бууруулах арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлээгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

—oOo—